



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/247

Номгон

“Нэг иргэн-Нэг мод” аяныг зохион байгуулах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“а”, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/7 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эх орон, байгаль дэлхийгээ хайрладаг уламжлалт монгол зан заншлаа дээдэлж, хүн бүр байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцох нөхцөлийг бүрдүүлэх, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нэг иргэн-Нэг мод” аяныг зохион байгуулсугай.

2.“Нэг иргэн-Нэг мод” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

О.Байгалмаа – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой хариуцсан мэргэжилтэн

Н.Пүрэвжаргал – Баянхонгор сумын Захирагчийн ажлын албаны дарга

С.Бурмаа – Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын агаар, хөрс, орчны бохирдол хариуцсан ажилтан

Т. Отгонбаатар – Хот тохижилт ОНӨААТҮГазрын захирал

Л.Сайнжаргал- Хот тохижилт ОНӨААТҮГазрын дендрологич

П.Уртнасан – Сум дундын ойн ангийн дарга

621010617


2.

Нарийн бичгийн дарга: Б.Намуун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

3.Баянхонгор аймгийн "Нэг иргэн-Нэг мод" аяныг амжилттай зохион байгуулж тайланг 06 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН